



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.06 № 504
танай _____ -ны № _____ -т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны 49 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

“Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн” нам нь 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

Хувийг: “Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн” намд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ЭСӨХБАЯР